



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 04 өдөр

Дугаар А/23

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.2, 60.1.21 дэх хэсэг 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь хэсэг, Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 35-дугаар тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд уламжлал болгон зохион байгуулагддаг "ТУУЛЬСЫН ХААН ЖАНГАР-2025" арга хэмжээнд ирж оролцсон уран бүтээлчдийн буудал, хоолны зардалд шаардагдах 1.960.000₮ (нэг сая есөн зуун жаран мянган) төгрөгийг Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж хөрөнгийн зарцуулалтыг тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Хэвлэлийн алба (Д.Баяраа)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

